



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/034

Мандалговь

Хугацаат цэргийн алба хааж буй
дайчидтай уулзалт зохион байгуулж
дэмжлэг үзүүлэх тухай

Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, Батлан хамгаалахын сайд аймгийн Засаг даргатай 2019 онд хамтран ажиллах гэрээний 3.2.9, Засаг даргын 2019 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 09 дүгээр зөвлөлийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дорноговь аймгийн Эрдэнэ суманд байрлаж буй Хилийн 0129 дүгээр ангид Дундговь аймгаас цэргийн албанд татагдан хугацаат цэргийн алба хааж буй дайчидтай уулзалт зохион байгуулах, цэргийн албаны үйл ажиллагаатай танилцахад зарцуулах хөрөнгийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Тус арга хэмжээнд шаардагдах 117500 (нэг зуун арван долоон мянга таван зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн) нягтлан бодогч (Д.Нандинцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

433190616

Аймгийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын
25-ны өдрийн 1234 дугаар захирамжийн хавсралт

ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Зарцуулагдах хөрөнгө	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ	Мөнгөн дүн (төгрөгөөр)
1	Хоормог	литр	15	3500	52.500
2	Чихэр	кг	5	5000	25.000
3	Ус	ширхэг	40	300	12.000
4	Ундаа	ширхэг	20	1400	28.000
Бүгд					117.500